

Батлав

Харилцаа холбооны зохицуулах
Хорооны дарга Г.Чинзориг

Батлав :

Ординат ХХ Компанийн
захирал П.Баярсайхан

Санхүүгийн болон биллинг системийн хөгжүүлэлт, дэмжих үйлчилгээ, мэдээллийн баазын аюулгүй байдлыг хариуцан ажиллах тухай гэрээ

2022 оны 05 сарын 10-ний өдөр

№ 7/2022

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид захиалагч гэх) ба түүнийг төлөөлж ЗУХАГ-ын дарга З.Эрдэнэчулуун, нөгөө талаас Ординат ХХК (цаашид гүйцэтгэгч гэх) ба түүнийг төлөөлж ерөнхий нягтлан бодогч Н.Энхзул нар харилцан тохиролцож Харилцаа холбооны зохицуулах хороонд ашиглагдаж байгаа санхүүгийн Unicus програм болон биллинг системийн хөгжүүлэлт, дэмжих үйлчилгээ, мэдээллийн баазын аюулгүй байдлыг хариуцан ажиллах тухай гэрээг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс нэг жилийн хугацаатай байгуулав. Энэхүү гэрээнд хэрэглэгдэж байгаа нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:

- “Програмын хөгжүүлэлт” гэдэгт одоо ажиллаж байгаа програмын модулиудын ажиллагааг сайжруулсан нэмэлт өөрчлөлтүүд, захиалагч талаас програмын ажиллагааг сайжруулахтай холбоотой тавьсан хүсэлтийн дагуу хийгдсэн програмын сайжруулалт зэргийг ойлгоно. Энд програм дээр шинээр хийгдэх модуль, зөвхөн тухайн байгууллагын онцлогтой холбоотой өөрчлөлт, хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотой програмын өөрчлөлт зэрэг өөрчлөлтүүд хамрагдахгүй болно.
- “Програмын дэмжих үйлчилгээ” гэдэгт санхүүгийн програм дээр ажиллаж байгаа нягтлан бодогч нарт програмтай холбоотой үүссэн аливаа асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж гүйцэтгэгч талаас өгч байгаа заавар, зөвлөгөөг ойлгоно.
- “Мэдээллийн баазын аюулгүй байдлыг хариуцах” гэдэгт програмд орсон мэдээллүүдийг бүрэн бүтэн хадгалах зориулалттай сервер компьютерт байнгын хяналт тавьж, засвар үйлчилгээ өртгөтгөл хийх, тогтмол хугацаанд мэдээллийн баазын нөөц үүсгэх, мэдээллийг гаднын аливаа халдлагаас найдвартай хамгаалах зэрэг үйл ажиллагааг ойлгоно.

Хоёр. Захиалагч талын хүлээх үүрэг

2.1 Програм дээр ажилладаг нягтлан бодогчдыг аль болох тогтвор суурьшилтай ажиллуулна. Аль нэг нягтлан бодогч солигдох тохиолдолд шинэ нягтлан бодогчийг нэг сараас доошгүй хугацаагаар програм дээр өмнөх нягтланг дагалдуулж ажиллуулан програм ашиглах мэдлэгийг бүрэн эзэмшүүлнэ. Шинэ ажилтан зайлшгүй гүйцэтгэгч талаас програмын сургалт авах тохиолдолд энэ гэрээнээс гадуур гүйцэтгэгч талын тарифын дагуу төлбөрөө төлж сургалтад хамрагдана.

Ординат ХХК
Захиалагч талын захирал
П.Баярсайхан

2.2 Захиалагч тал энэхүү гэрээний төлбөрийг гэрээний хугацаа эхэлснээс хойш 7 хоногт багтаан төлөх үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгч талын хүлээх үүрэг

3.1 Програмын хөгжүүлэлт, програмын дэмжих үйлчилгээг гэрээний хугацаанд захиалагч талаас ирүүлсэн хүсэлтийн дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

3.2 Мэдээллийн баазын аюулгүй байдлыг хариуцах ажлыг “Үндэсний Дата төв” УТҮГазартай хамтран зохион байгуулна. Өөрөөр хэлбэл техник технологийн зориулалтын орчинд мэдээллийн баазыг хадгалж хамгаална.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Энэ гэрээний хугацаа дуусахаас өмнөх нэг сарын хугацаанд аль нэг тал гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах санал гаргаагүй тохиолдолд уг гэрээний 5.1-д заасан төлбөрийг захиалагч тал гүйцэтгэгч талд төлснөөр энэхүү гэрээг дээрх нөхцөлөөр дахин нэг жилээр сунгагдсанд тооцно. Хэрэв гэрээний аль нэг заалтад өөрчлөлт орвол хоёр тал энэхүү өөрчлөлтийг бичгээр үйлдэж гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан эх гэрээний нэг адил мөрдөнө.

4.2 Энэхүү гэрээг аль нэг тал дангаараа цуцлах эрхгүй.

4.3 Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарвал асуудлуудыг хоёр тал аль болох харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд асуудлаа шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.4 Гэрээгээр тохиролцоогүй бусад асуудлыг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.


Тав. Гэрээний үнэ

5.1 2022.05.10-2023.05.10 хүртэлх гэрээний нийт үнэ – 8 800 000 (Найман сая найман зуун мянган) төгрөг.

Гэрээ байгуулсан :

Харилцаа холбооны зохицуулах
хороог төлөөлж:

ЗУХАГ-ын дарга

 З.Эрдэнэчулуун

СХ-ийн дарга

Н.Халиунаа

Хаяг:

СБД Д.Сүхбаатарын гудамж-13,
Метро бизнес төв А-блок 5 давхар
Утас: 304258

Ординат ХХ Компанийг
төлөөлж:

Нягтлан бодогч



Н.Энхзул

Хаяг:

БГД 5-р хороо Энхтайвны
өргөн чөлөө-92, 21тоот
Харилцах данс: Хас банк
5002227956

